БАТЛАВ.
АЖ, ҮЙЛДВЭР, ЭРДЭС
БАЯЛГИЙН САЙД
Г.ДАМДИНҮРЭМ

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД
Г.ТЭМҮҮЛЭН

2026 оны 10 дугаар сарын 30 -ны өдөр

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт “Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглахтай холбогдсон харилцааг Засгийн газраас батлсан тусгай журмаар зохицуулж болно” гэж заасан.

Ингэснээр авто зам, төмөр замын салбарт Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр хэрэгжүүлж буй зарим төсөл, хөтөлбөрүүдэд шаардагдах элс, хайрга, барилгын материалыг төсөл гүйцэтгэгч нарт богино хугацаанд түргэн шуурхай нийлүүлэх боломжийг бүрдүүлсэн байдаг.

Сүүлийн жилүүдэд уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөгжлийн чиг хандлагатай уялдан уул уурхайн бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр өсөж байгаатай холбоотойгоор уул уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх тусгай зориулалтын авто замын бүтээн байгуулалтын ажил нэмэгдэж, түүнд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалын эрэлт, хэрэгцээ өссөөр байна. Энэхүү өсөн нэмэгдэж буй эрэлт, хэрэгцээг богино хугацаанд найдвартай эх үүсвэрээс хангах шаардлага гарч байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна.

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.2.2-т “Хил дамнасан төмөр замын холболтыг барьж, хилийн боомтуудыг хатуу хучилттай авто замаар холбож, ачаа тээврийн терминалуудыг байгуулж, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг жилд 100.0 сая тоннд хүргэнэ” гэж заасан байна.

Энэ нь Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл болно.

1.2.Практик хэрэгцээ, шаардлага

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д ""түгээмэл тархацтай ашигт малтмал" гэж зам, барилгын материалын зориулалтаар ашиглах боломжтой элбэг тархалт бүхий элс, хайрга, тоосгоны шавар, хүрмэн, боржин, дайрганы зориулалттай барилгын чулууны хуримтлалыг", мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт "Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглахтай холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан тусгай журмаар зохицуулж болно" гэж тус тус заасан.

Түүнчлэн, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийг үндэслэн Засгийн газрын 2025 оны 82 дугаар тогтоолоор баталсан журмаар зөвхөн Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлж буй зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах асуудлыг зохицуулсан байдаг.

Сүүлийн үед уул уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх тусгай зориулалтын авто замын бүтээн байгуулалтын ажил нэмэгдэж байгаатай холбоотойгоор түүнд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалын эрэлт, хэрэгцээ мөн өсөн нэмэгдэж байна. Энэхүү эрэлт, хэрэгцээг богино хугацаанд хангах зайлшгүй шаардлага байгаа боловч Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд заасан тусгай зөвшөөрөл авах үйл ажиллагаа, талбайн хэмжээ зэргээс шалтгаалж төсөл гүйцэтгэгч нарт эрдсийн түүхий эдийг богино хугацаанд нийлүүлэх боломжгүй байна.

Иймд уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх үүднээс тусгай зориулалтын авто замыг барих, засварлахад шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалын эрэлт, хэрэгцээг богино хугацаанд нийлүүлдэг болох эрх зүйн зохицуулалтыг бий болгох практик шаардлага байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 3 зүйлтэй байна. Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1-д заасны дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулах бөгөөд дараах асуудлыг тусгана. Үүнд:

1 дүгээр зүйлд Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахтай холбоотой харилцааг зохицуулах журам батлах эрхийг Засгийн газарт олгосон зохицуулалтыг тусгана.

2 дугаар зүйлд Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт зөвхөн Улсын Их Хурал, Засгийн шийдвэрээр бус эрэлт, хэрэгцээнээс нь хамаарч авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах зохицуулалтыг тусгана.

3 дугаар зүйлд Хуулийг дагаж мөрдөх хугацааны талаарх зохицуулалтыг

тусгана.

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар тусгай зориулалтын авто замыг барихад шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагаа хялбар түргэн шуурхай болох бөгөөд улмаар материалын зардал, хугацааг бууруулж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлнэ. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нэмэгдэж, эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу боловсруулагдсан, Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцсэн байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл боловсруулахгүй болно.

---oOo---